

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2023 ОНЫ
09 ДҮГЭЭР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ**

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, аймгийн Засаг даргаас 12 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

Аймгийн хэмжээнд гал түймрийн объектын дуудлага 1, эрэн хайх, аврах ажиллагааны 2 дуудлага бүртгэгдсэн байна.

“ӨСВӨРИЙН АВРАГЧ-2023” өмнөд бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг 2023 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулж, тэмцээнд оролцогчид хээрийн нөхцөлд 2 хоногийн хугацаанд тусгайлан бэлдсэн хотхонд байрлаж, өөрсдийн тэсвэр хатуужлыг сорьж, цэргийн болоод аврагчийн ажлын онцлог, ур чадвараас суралцан ажилласан.

Тэмцээнд Өмнөд бүсийн 6 аймгийн /Дорноговь, Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Говьсүмбэр/ өсвөрийн аврагч бүлгэмийн гишүүд хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс Говьсүмбэр аймгийн ерөнхий боловсролын 2-р сургуулийн Билгүүнтамир ахлагчтай “Соёмбо” бүлгэм “Тэргүүн байр”-т шалгарч, Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээр, “Дэд байр”-т Өвөрхангай аймгийн Баттогтох ахлагчтай “Шунхлай” бүлгэмээр тус тус шалгарсан.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд Боловсролын байгууллагын барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, Гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах” хяналт, шалгалтыг 2023 оны 8 дугаар сарын 14-ний өдрөөс 8 дугаар сарын 31-ний өдрүүдэд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллалаа.

- Шалгалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээд, ААНБ-10,
- Илрүүлсэн зөрчил давхардсан тоогоор-35,
- Газар дээр нь төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн 5 зөрчлийг арилгуулах талаар заавар зөвлөмж өгч, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн албан шаардлага-10 ыг хүргүүлж, Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газарт заасан хугацаанд disaster_inspector@nema.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн.

Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн хяналт шалгалт Онцгой байдлын ерөнхий газрын даргын удирдамжийн хүрээнд Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа “Авто засвар, үйлчилгээ угаалгын газрын барилга байгууламжид”-д гүйцэтгэлийн хяналт шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай, гамшгаас хамгаалах тухай, галын аюулгүй байдлын тухай хууль, холбогдох норм, стандарт, дүрэм журмыг мөрдлөгө болгон зохион байгуулан ажиллалаа.

Хяналт шалгалтаар 9 аж ахуй нэгж, байгууллага хамрагдаж, 118 зөрчил дутагдалыг заагдсанаас 97 зөрчил дутагдал арилж, 21 зөрчил дутагдал төлөвлөгөөний дагуу урт хугацаанд гүйцэтгэгдэж, өнөөдрийн байдлаар 82,2 хувьтай биелэгдээд байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны А/154 дүгээр тушаалаар батлагдсан “Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам”-ын 1 дүгээр хавсралтыг үндэслэн 7 иргэн, аж ахуй нэгж байгууллагын гаргасан хүсэлтийн дагуу галын аюулгүй байдлыг шалган илэрсэн зөрчил дутагдалд мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 7-г олгож 175.000 төгрөгийг тэмдэгтийн хураамжийн хуулийн дагуу орон нутгийн орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу Улсын комисст орж Сүмбэр сумын Тэрэгт хорооллын цахилгаан дамжуулах агаарын шугам, тагтын эгнээний худгийг хүлээж авах комисст оролцож санал дүгнэлтийг гаргаж, үүрэг чиглэл өгч ажилласан.

Тус аймгийн Сүмбэр сумын 1, 3 дугаар багт байрлах “Ник Петровис” ХХК, “Нью энерги” ХХК шатахуун түгээх станцуудын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хянаж, арга зүйн зөвлөгөө өгч баталгаажуулсан.

2023 онд зохион байгуулах Гамшгаас хамгаалах ангиллын сургалт нэгдсэн төлөвлөгөөний хүрээнд

- Политехникийн коллеж
- Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль

Нийт 2 удаа нийт 26 ажилтан, албан хаагч, сурагчид, иргэдэд Газар хөдлөлт, Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах аргачлал, гамшгийн үед хэрхэн ажиллах тухай анхан шатны ойлголт, галын аюулгүй байдлын тухай ойлголт, гал унтраах дадлага сургууль, “what3words” программын ашиглах талаар 4 цагийн сургалт зохион байгуулан ажиллав.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар Шилдэг офицер, шилдэг ахлагч шалгаруулах тэмцээнд Онцгой байдлын газраас 4 офицер, 5 ахлагч хамрагдсан.

Онцгой байдлын ерөнхий газар болон Цаг уур орчин шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээ 3, Онцгой байдлын газрын үйл ажиллагааны чиглэлээр 5 мэдээг Онцгой байдлын газрын болон “go.nema.gov.mn” сайтад байршуулж “Чойрын зар”, “Боржигин нутаг минь”, “Шивээговь нэгдсэн зарын групп”, “Говьсүмбэр аймаг” “govisumber.gov.mn”, “Govisumbernews.mn” гэсэн хаягуудад шейрлэж иргэдэд хүргэн ажилласан. “Go.nema.gov.mn” сайтад 2023 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 7157 хандалт хийгдсэн байна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2023 оны 09 дүгээр сарын нийт татварын орлогын төлөвлөгөө 8 653 685,2 мянган төгрөг гүйцэтгэлээр 8 433 973 мянган төгрөг буюу 97,5%, үүнээс Улсын төсвийн орлогын төлөвлөгөө 1 236 819 мянган төгрөг гүйцэтгэлээр 1 408 614 мянган төгрөг буюу 114% гүйцэтгэлтэй байна. Сумын төсвийн орлогын төлөвлөгөө 5 377 266,2 мянган төгрөг төвлөрүүлэхээс 5 744 949 мянган төгрөг буюу 106,8%, аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 2 039 600 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1 997 000 мянган төгрөг буюу 97,9%-ийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.

Татвар төлөгчдийн бүртгэлийг сайжруулж, татварын бааз суурийг нэмэгдүүлэх хүрээнд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 698 хуулийн этгээд бүртгэлтэй байсан бол 2023 оны 09 дүгээр сарын 25-ны байдлаар 707 болж өссөн Үүнд: Татвар төлөгчдийн хариуцлагын хэлбэрээр харуулбал: Үүнд: ХК-1, ХХК-370, ББН -5, ЗБН -11, Хоршоо - 31, ХЗХоршоо-1, ОНӨҮГ- 6, Салбар- 66, төсөвт болон төрийн бус байгууллага, сан ОНБ – 216 байна.

Санхүүгийн хяналт аудитын алба:

Санхүүгийн хяналт шалгалтыг төлөвлөгөөт 8, төлөвлөгөөт бус 3 байгууллагад нийт 11 байгууллагад хийж 287 870,8 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 11 141,0 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгуулахаар, 7 212,2 мянган төгрөгийг хувь хүнд нь буцаан олгуулахаар, улсын төсөвт төвлөрүүлэхээр 12 016,8 мянган төгрөг нийт 30 370,0 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоож 18 971,3 мянган төгрөгийг зөрчлийг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн. Мөн 12 224,6 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, 226 234,9 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өгч ажиллалаа.

Үр дүн: Актын барагдуулалт 47,2 хувь. Нийт тогтоосон нөхөн төлбөрийн актаас 14 361,8 мянган төгрөгийн акт барагдсан, 16 008,2 мянган төгрөгийн актын барагдуулах хугацаа нь болоогүй байна.

Тохижилт-Сүмбэр ОНӨААТҮГ-ын 2022, 2023 оны 08 сар хүртэлх үйл ажиллагаанд дотоод аудит хийж шалгалтын явц 60 хувьтай байна. 2023 оны 1-7 дугаар сарын шилэн дансны мэдээ оруулалтад нэг бүрчилсэн хяналт шалгалтыг хийлээ. Шалгалтаар нийт 568 204,5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн тул зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан бичиг хүргүүлэн ажилласан.

Сүмбэр сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2022-2023 оны 08 сар хүртэлх санхүүгийн үйл ажиллагааны хяналт шалгалтын явц 95 хувьтай, Талын Илч ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны дотоод аудитын шалгалтын явц 50 хувьтай, Сүмбэр сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2022-2023 оны 09 сар хүртэлх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт 30 хувьтай, Дуу бүжгийн Боржигин чуулгын 2022-2023 оны 07 сар хүртэлх үйл ажиллагааны дотоод аудитын шалгалтын явц 95 хувь, АЗДТГазрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагааны хяналт шалгалтын явц 70 хувьтай тус тус үргэлжилж байна .

Статистикийн чиглэлээр:

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн Хөдөө аж ахуйн 3 мэдээг хуваарийн дагуу сумаас хугацаанд нь бүрэн авч сар бүр Үндэсний статистикийн хороонд дамжуулсан.

Аж үйлдвэрийн салбарын АҮ-1, Зочид буудлын үйл ажиллагааны ЗБ-1, Зоогийн газрын үйл ажиллагааны ЗГ-1, АҮСҮ-1 мэдээнүүдийг ААНБ-аас хугацаанд нь бүрэн авч Үндэсний статистикийн хороонд дамжуулсан.

Аймгийн 2023 оны 08 сарын Нийгэм, эдийн засгийн танилцуулга болон хэвлэлийн бага хурлыг бэлтгэн нийтэлсэн.

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн сарын Үнэ-21 мэдээг 1 удаа, 7 хоногийн үнийн Үнэ-2 мэдээг 4 удаа дамжуулсан.

Ажиллах хүчний судалгаа, Ногоон хүчний ажлын байрны судалгааны 30 өрхөөр судалгаанд явсан. Судалгааны тодруулгуудыг тухай бүр тодруулан Үндэсний статистикийн хороонд дамжуулсан.

3 жил тутам хийгддэг Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны айл өрхийн тодруулгыг 2023 оны 08 дугаар 25-ны өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрүүдэд хийсэн. Уг тодруулганд 1600 өрхийг хамруулан 1 хянагч, 8 судлаач ажилласан. Холбогдох тайлан мэдээг гаргаж Үндэсний статистикд хүргүүлсэн.

3 жил тутам хийгддэг Амьдрах орчны аюулгүй байдлын судалгааны багийн 5 хүн аймагт 7 хоног ажиллаж 60 айл өрхөөс судалгаа авсан. Хэлтсийн зүгээс шаардлагатай мэдээлэл, хүний нөөцөөр хангаж ажиллалаа.

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын фейсбүүк хуудас, Хууль Эрх зүйн хэлтсийн фейсбүүк хуудсаар дамжуулан “Боловсролын ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Таны данс, таны хариуцлага цахим залилангаас урьдчилан сэргийлэх, АА бүлгэмийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж мэдээллийг түгээж ажилласан. /хандалтын тоо-Давхардсан тоогоор 179/

Архивын тасаг:

Архивийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 2 хөмрөгийн 17 хадгаламжийн нэгжийн 1192 хуудас, 581 заалт, 3003 хүний нэр, 581 байгууллагын нэр, 1655 газар зүйн нэр, 1198 фотошоф, 1198 скайнер, 1683 холболт хийж ажилласан.

2023 оны 09 дүгээр сард 40 иргэнд лавлагаа гаргаж үйлчилгээ үзүүлсэн.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан - 222
- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 101
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо – 23

- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 7
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо - 2
- Үрчлэлтийн бүртгэлийн тоо- 0
- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэлийн тоо - 3
- Эцэг тогтоолтын бүртгэлийн тоо - 2
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 1
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн - 49
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо - 33
- Тоон гарын үсэг олголт - 298

Нийт - 741

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 4
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 9
- Гэрээний бүртгэл - 58
- Барьцааны гэрээний бүртгэл - 169
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга - 7

Нийт - 247

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 2
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт -3
- Татан буугдсан хуулийн этгээдийн бүртгэл - 0

Нийт - 5

Архивын чиглэлээр:

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар - 10
- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар - 0
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 53

Нийт- 63

Төрийн үйлчилгээг нийт 1056 иргэнд хүргэсэн байна.

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД

Тус алба нь хэргийн газрын үзлэг-14, үүнээс хүний амь нас хохирсон-1, хулгайлах гэмт хэрэг-2, дээрэмдэх-0, зам тээврийн осол-4, бусад-7, Хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт-14, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх ажиллагааны 158 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан байна. Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 36 үүнээс Хүнд-1, Хүндэвтэр-0, хөнгөн-20, гэмтлийн зэрэгт хамаарахгүй-10, гэмтэл тогтоогдоогүй-5

Цогцост хийсэн шинжилгээний тоо-1

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд хамтарсан багийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих, чиглэл өгөх зорилгоор зохион байгуулагдсан салбар зөвлөлийн 2 дугаар хуралдаанд ангийн дарга, дэд хурандаа М.Батбаяр оролцсон.

Байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлан, таниулах зорилгоор аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн бүрэлдэхүүн байгууллагатай хамтран

“Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Нээлттэй хаалганы өдөрлөгт 92 иргэн хамрагдсан.

2023 оны 9 дүгээр сарын байдлаар 102 хоригдол ар гэрийн хүсэлтийн дагуу цахим уулзалтад хамрагдсан

Хоригдлуудад тулгамдаад буй асуудлуудад тухай бүр эрх зүйн зөвлөгөө өгч, яриа таниулга хийн нийт 160 хоригдлын гаргасан хүсэлтийг хүлээн авч ангийн удирдлагад танилцуулан холбогдох албан тушаалтан, байгууллагад зохих журмын дагуу явуулж зөрчилгүй шийдвэрлэж ажилласан.

Тайлант хугацаанд суллахад бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран ажиллах төлөвлөгөөний хүрээнд 2 цагийн сургалт зохион байгуулсан. Суллагдах дөхсөн хоригдлуудыг холбогдох сургалтад хамруулж, суллагдсаны дараа 24 хоригдлыг “малчин”, “Хувийн компанид туслах ажилтан” гэх зэрэг ажлын байранд зуучилсан.

Гэм хорын төлбөртэй хоригдлуудаас цалинтай ажлын байраар 3 хоригдол хөдөлмөрт хамрагдаж байгаа бөгөөд ангийн байрлалд үйл ажиллагаа явуулж байгаа “ОСО КОНСТРАКШ” ХХК-ний хөнгөн блок үйлдвэрт ажиллаж байна. Тус 3 хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс 1,138,500 төгрөгийг хохирол төлбөрт шилжүүлэхээр хорих ангийн дансанд байрлуулаад байна.

Иргэний цахим үнэмлэхний зөрчилтэй буюу Иргэний үнэмлэхний хүчинтэй хугацаа сунгах (25, 45 нас) 12 хоригдол, хаяж гээгдүүлсэн дахин захиалах 18 хоригдол байна. Үүнээс гадна иргэний цахим үнэмлэхний сунгалт хийх шинээр захиалах 8 хоригдлын хүсэлтийг холбогдох материалын хамт Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлээд байна.

Хорих ангид сувилагч нар амбулаторын үзлэгээр давхардсан тоогоор 686 хоригдол, давтан үзлэгт 337 хоригдол, эмчийн хяналтад байгаа 4 хоригдолд давхардсан тоогоор 275 удаагийн үзлэг хийж эмчийн жороор эм олгож, зөвлөгөө өгч ажиллалаа.

Сувилахуйн тусламж үйлчилгээг эмчийн зааврын дагуу хоригдол, хоригдогч нарт тэгш хүртээмжтэй, түгээмэл үйлдлүүдийг стандартын дагуу хийж гүйцэтгэж байна. Эм, тариаг хэрэглэхдээ таван зөвийн зарчмыг баримтлан, эмийг цаг тухайд нь харж уулгаж, уусан эсэхэд нь хяналт тавин ажилласан. Хийгдсэн эмчилгээ, тусламжийг бүртгэлд тогтмол тэмдэглэн ажиллаж хэвшээд байна.

Нийт 219 хоригдолд сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж, цээжний рентген зураг, сүрьеэгийн асуумж, авсан. Үзлэгээр цээжний зураг өөрчлөлттэй 23 хоригдлоос өглөө оройн цэрний шинжилгээ авсан.

2023 оны 9 дүгээр сард нийт 19 хоригдолд “Үндсэн хуулийн 2 дугаар бүлэг”, “Эрүүгийн хуулийн 5 дугаар бүлэг”, “ШШГТХ-ийн 21 дүгээр бүлэг”, “Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар бүлэг”, “Хорих ангийн дотоод журам”, “Хяналтын хуудас хэрэглэх журам”, “Аюулгүйн тойрог тогтоох журам”, “Дасан зохицох чадвар суулгах”, “Харилцаанд үүсэх зөрчил”, “Биеэ авч явах байдал”, “Хандлагаа өөрчлөх нь” зэрэг 12 сэдвээр 2 удаагийн давтамжтай нийт 24 цагийн сургалтыг зохион байгуулсан.

Хоригдлын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, авъяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор давхардсан тоогоор гитар хөгжмийн дугуйланд 6 хоригдол, бясалгалын сургалтад 35 хоригдол, шагайн харваан дугуйланд 17 хоригдол, шатрын дугуйланд 23 хоригдол, даамны дугуйланд 21 хоригдол, морин хуурын дугуйланд 6 хоригдол, ширээний теннисний дугуйланд 30 хоригдол, Архичид аминчлахуй сургалтад 17 хоригдол, монгол бичгийн дугуйланд 13 хоригдол, нийт 9 төрлийн сургалт, дугуйлангийн үйл ажиллагааг идэвхжүүлэн 168 хоригдол хамрагдаж байна.

Политехникийн коллежтэй 2022-2023 онд хамтран ажиллах гэрээний хүрээнд “Хүнд машин механизмийн засварчин” мэргэжлээр 15, “Гагнуурчин” мэргэжлээр 15, “Авто машины засварчин” мэргэжлээр 14, нийт 44 хоригдлыг мэргэжлийн сургалтад хамруулсан.

Мөн Политехникийн коллежтэй хамтран ажиллах гэрээ байгуулан “Зам барилгын машин механизмын оператор”, “Металл боловсруулах машины оператор” мэргэжлээр 26 хоригдлыг мэргэжлийн сургалтад хамруулахаар холбогдох мэдээллийг Политехникийн коллежид хүргүүлээд байна.

Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн дадал олгох чиглэлээр хорих ангид өнөөдрийн байдлаар 212 хоригдол ял эдэлж байгаагаас 153 хоригдлыг хөдөлмөрт хуваарилсан нь нийт 72,8 хувийг ажлын байраар хангаж хөдөлмөрт хамруулаад байна. Тус хоригдлуудаас хорих ангийн үйлдвэрийн хэсэгт нийт 48 хоригдлыг хөдөлмөрийн дадал олгож мужаан цех, гагнуур, даалин оёх, гөлөм оёх, суран эдлэх хийх, оёдол хийх, гар урлал хийх зэрэг төрлүүдээр хөдөлмөрт хамруулж хүмүүжигч нарын үйлдвэрлэж урласан бүтээлийг арвижуулах, чанаржуулах, олон нийтэд таниулах зорилгоор үзэсгэлэнгийн өрөөг тохижуулан бүтээлүүдийг байршуулсан.

ЦАГДААГИЙН ХЭЛТЭС

Цагдаагийн хэлтэс нь Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 202/ “Гэмт хэрэг зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах” журамд заасны дагуу 2023 оны 09 дүгээр /08.21-09.20/ сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 123 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн 35, зөрчлийн 88 гомдол мэдээлэл байна. Тайлангийн хугацаанд зөрчил үйлдсэн 2325 иргэнийг эрх бүхий албан тушаалтнаас болон шүүхээс 68,066,500 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 2 хүнийг эрүүлжүүлж, 10 хүнийг шүүхээр баривчлуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 8 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан байна.

Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор давхардсан тоогоор худалдаа, үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг 51 цэгийн үйлчилгээний цагийн хуваарьт өдөр тутам хяналт шалгалт хийж, зөвлөгөө өгч ажиллав.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гудамж талбай, олон нийтийн газарт гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр сүмбэр сумын нутаг дэвсгэрт найрамдал хотхон, дэнж, төмөр зам, аяганы хонхор чиглэлд өдөр 14:00-20:00, орой 20:00-04:00 цагуудад, Баянтал сум, Шивээговь сумдын нутаг дэвсгэрт 10:00-16:00 цаг, 18:00-00:00 цагийн хооронд эргүүлийг тасралтгүй зохион байгуулж давхардсан тоогоор 278 алба хаагч 1668 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгууллага, аж ахуйн нэгжийн халдвар хамгааллын дэглэмийг сахиулж, заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Энэ оны 09 сард гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг цахим хэлбэрээр олон нийтэд хүргэх, хууль сурталчилах, ухуулах, цаг үеийн болон нөхцөл байдлын талаарх мэдээ мэдээллийг түгээх ажлыг тасралтгүй зохион байгуулж, төв, орон нутгийн холбогдох байгууллагаас цахим орчинд нийтлэсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх санамж, анхааруулга, зөвлөмж 14 видео шторк 16, бусад 8 нийт 38 мэдээллийг “Говьсүмбэр аймгийн цагдаагийн хэлтэс” пэйж хуудсанд байршуулж, иргэд, олон нийтэд түгээж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан байна.

Сүмбэр сумын Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “Миний ирээдүйн мэргэжил” арга хэмжээг хуваарийн дагуу зохион байгуулж, Ерөнхий боловсролын сургуулиудын 10 дугаар ангийн 28 сурагчдыг байгууллагын үйл ажиллагаатай танилцуулж ажиллалаа.

Шивээговь сумын ГХУСАЗСЗ болон тус сумын шагайн холбоотой хамтран сургууль, цэцэрлэг хичээллэж эхэлсэнтэй холбогдуулан хүүхдийг зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургууль, цэцэрлэгийн бүс болон сумын төвийн гол замд 2 ширхэг тээврийн хэрэгслийн хурд сааруулагчийг тус тус шинээр байршуулсан.

Жил бүрийн 9 дүгээр сарын 10-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлдэг “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг санан дурсах, тэдний гэгээн дурсгалыг мөнхжүүлэх” 28 дахь өдөр тохиож

буйтай холбогдуулан хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэж, замын хөдөлгөөнд оролцохдоо авто машиныхаа гэрлийг асаахыг уриалж хөдөлгөөнд оролцуулсан.

"Хичээл эхэллээ" ерөнхий арга хэмжээний хүрээнд хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг ерөнхий боловсролын 5 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 7 цэцэрлэгийн хичээлийн шинэ жилийн нээлтийн арга хэмжээний үеэр нийт 13 цэгт 30 алба хаагч 07:30-10:00 цагт үүрэг гүйцэтгэж, хэв журам сахиулах, сургууль, цэцэрлэг орчмын замын хөдөлгөөний болон бяцхан зорчигчдын аюулгүй байдлыг хангуулж, иргэд, жолооч нарт санамж сэрэмжлүүлэг өгч, тээврийн хэрэгслийн ойрын гэрлийг асаалгаж замын хөдөлгөөнд оролцуулж ажиллалаа.

Говьсүмбэр аймаг дахь Уул уурхайн жишиг сургууль, политехник коллежийн 40 оюутанд "Цахилгаан хөдөлгүүрт скүүтер, унадаг дугуй, мопед, мотоцикльтой замын хөдөлгөөнд оролцохдоо анхаарах асуудал", "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль" болон согтууруулах ундааны хор уршиг, хэрэг зөрчилд холбогдох, түүнд өртөж, хохирохоос сэргийлэх чиглэлээр танхимын сургалт зохион байгуулж ажилласан.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Шивээговь, Баянтал сумдын салбар зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланг иргэдэд танилцуулах арга хэмжээнд оролцож, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын тайланг танилцуулж, иргэдийн асууж, сонирхосон асуултанд хариулт өгч, санамж 70, сэрэмжлүүлэг 150 ширхэгийг тарааж ажилласан. Мөн үеэр "Оорцог элгэн" зөрлөгийн иргэдэд тайлан танилцуулах арга хэмжээний үеэр зөрчилгүй 10 жолоочид гарын бэлэг гардуулах арга хэмжээг зохион байгуулсан.

ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр:

2023-2024 оны хичээлийн жилийн хүрээнд Багш нарын бага хурлыг СӨБ, ЕБС, МББ-ын багш нар болон удирдлага 300 гаруй албан хаагчдын хүрээнд амжилттай зохион байгуулсан. Тус хурлаар өнгөрсөн хичээлийн жилийн зорилтын тайлан, дүн тайлан, Боловсролын ерөнхий хуулийн танилцуулга, боловсролын шинэчлэлийн бодлого, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг танилцууллаа. Мөн шинэ хичээлийн жилийн аймгийн зорилго зорилтыг боловсруулж, сургууль бүр дээр танилцуулах хурал зохион байгуулж, санал халэлцүүлэн баталлаа.

2023-2024 оны хичээлийн жилд 1-р ангид элссэн суралцагчдыг СББ-ын судалгаанд хамруулах бэлтгэл ажлын хүрээнд 1-р ангийн 20 багш, Eduten цахим платформ сургалтанд ашиглах арга зүйн сургалтанд 3-4-р ангийн багш, мэдээлэлзүйн багш, сургалтын менежерүүд зэрэг нийт 40 багшийг тус бүр онлайн сургалтанд хамруулж, 14 багш, 5 сургалтын менежерүүдэд нэвтрэх нэр үүсгэж, судалгааны даалгавар татах, зөвлөмж болон сургалтанд ашиглах арга зүйн сургалтыг нийт 28 багш нарын хүрээнд зохион байгуулж, 5-6-р ангийн Англи хэлний сургалтын хөтөлбөр боловсрууллаа.

Орон нутагт инновацийн соёлыг түгээх зорилгоор **MON-NKC 2023** хөтөлбөрийг зохион байгуулах, инновацийн зөвлөлийг хуралдуулж, хамтын үйл ажиллагааг сайжруулах хэлэлцүүлэг өрнүүлээ. Говийн бүсийн түншлэл-2023 үзэсгэлэн худалдаанд оролцож, иргэдийг "MON-NKC 2023 хөтөлбөрт" идэвхтэй оролцож, орон нутагт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, шинэ санал санаачилгатай бизнес эрхлэх танилцуулга хийж, боршур гарын авлага нийт 40 иргэнд түгээлээ.

Иргэдийн инновацийн санаачилгуудыг дэмжин 20 сая төгрөгийн грант олгох "**Mon-X 2023**" хөтөлбөрийн олон нийтэд зориулсан онлайн Bootcamp сургалтанд 8 цэгээс нийт 40 иргэдийг хамрууллаа. "**Mon-X 2023**" хөтөлбөрийн танилцуулгыг олон нийтэд хүргэх зорилгоор танхимын сургалт зохион байгууллаа. Сургалтад 36 иргэд хамрагдаж, төсөл боловсруулах төслөө илгээх арга барилд суралцлаа.

Бүх шатны боловсролын сургалтын байгууллагуудын 2023-2024 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажилд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв. Шалгалтаар нийт 38 зөрчил дутагдал илрүүлэн 12 зөрчлийг арилгуулахаар 5 байгууллагад хугацаатай албан шаардлага хүргүүлээ. Албан шаардлагын биелэлт тооцох хугацаа болоогүй байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр:

Гэр бүл, хүүхдийн чиглэлээр аймгийн Цагдаагийн хэлтэс болон Цахилгаан дамжуулах сүлжээний ТӨХК-ны албан хаагчдад гэр бүлийн боловсрол олгох сургалтыг нийт 36 иргэнийг хамруулан зохион байгуулсан.

Сургалтаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Гэр бүлийн тухай хууль”, “Гэр бүлийн харилцаа”, “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдвүүдийн хүрээнд мэдээлэл өгч, харилцан ярилцан, зөвлөгөө зөвлөмж өгч сургалтыг зохион байгуулсан. Сургалтад хамрагдсан иргэд хуулийн тухай мэдлэг ойлголтоо нэмэгдүүлж, гэр бүлийн харилцаандаа анхаарах зүйлс болон хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийн талаар ойлголттой олгосон.

Залуучуудын чиглэлээр 1 ДҮГЭЭРТ ХҮҮХЭД” УРИАН ДОР “ХҮҮХДИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ОРОЛЦОО” ХӨТӨЛБӨР –ийг хэрэгжүүлэн Хүүхдэд амьдрах ур чадварыг эзэмшүүлэн хүүхдэд байгаа давуу талыг олж харахад нь туслах, түүнийг ойлгуулах, тэднийг үнэ цэнэтэйд тооцох, хүндэтгэн харилцаж эрүүл харилцаа бий болгох зорилгоор ерөнхий боловсролын 1-р сургуулийн 6-12-р ангийн сурагчдад “ХҮҮХДИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ОРОЛЦОО” сургалтыг 2023 оны 09 сарын 13-ны өдрөөс 09 сарын 27-ны өдрүүдийн хооронд 34 удаагийн сургалтыг нийт 530 сурагчдад зохион байгуулсан.

Сургалтын үр дүнд хүүхдүүд харилцаа хандлага, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн нөхцөл байдалд ирээдүйн амьдралаа маш сайн авч явах чадваруудыг эзэмшиж, амьдралынхаа туршид тулгарч болох асуудлуудыг мэддэг бас түүнээс гарах арга зам, ур чадваруудыг эзэмшсэнээр ирээдүйд болох үйл явцад бэлтгэлтэй байж эрүүл, эерэг ухаанаар шийдвэр гэргах чадвартай болоход нөлөөлсөн юм. Мөн хүүхдүүд өөрийгөө болон бусдыг аливаа төрлийн хүчирхийлэл болон эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, бусдыг ялгаварлан гадуурхаж, хэн нэгнийг хэцүү байдалд оруулахгүй байх талаар ойлголттой болсон ба анги баг хамт олноороо бат бөх, найрсаг харилцааг бэхжүүлэх дасгал ажиллаж, хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлэхэд нөлөөлсөн.

Биенийн тамир, спортын чиглэлээр:

Улаанбаатар хотноо анх удаа зохион байгуулагдсан “Улаанбаатар-2023” Зүүн Азийн залуучуудын наадамд аймаг орон нутгаа төлөөлж, спортын 3 төрөлд 4 тамирчин оролцлоо.

Хичээлийн шинэ жилд зориулж “Грассрүүтс-Эхлэл” тэмцээнийг зохион байгуулж, ерөнхий боловсролын гурван сургуулийн 21 багийн 210 сурагчдыг 2 насны ангилалаар хамрууллаа.

“ЭЛФ КАП-2023” жюүжицүгийн 24 багийн 500 гаруй тамирчид оролцсон тэмцээнд манай аймаг 2 дасгалжуулагч 13 тамирчинтай оролцож, 2 алт, 2 мөнгө, 1 хүрэл медаль хүртлээ.

2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар усан спорт сургалтын төв нийт 485 иргэнд үйлчилсэний 465 хүүхэд үйлчилгээ авсан байна.

Эрүүл мэндийн талаар: Эрүүл мэндийн үзүүлэлт

Үзүүлэлт	2022 оны 9 сар	2023 оны 9 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	276	256
Гэрийн төрөлт	2	1
Амьд төрсөн хүүхэд	273	257
Амьгүй төрөлт	3	0
Нас баралт	67	56
Эмнэлгийн нас баралт	18	18
Хоног болоогүй нас баралт	7	4
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	3	3
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	1	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	4601	4300
Амбулаторийн үзлэг	93955	91794

Халдварт өвчин	2524	237
----------------	------	-----

Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/21, 23 тоот удирдамжаар хоол, хүнс үйлдвэрлэлийн 2, цэвэрлэх байгууламж, амралт жуулчны бааз, халуун ус, төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн 9, нийт 11 газарт төлөвлөгөөт шалгалтыг гүйцэтгэсэн. Шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах 40 заалт бүхий хугацаатай албан шаардлагыг 7 газарт, 8 заалт бүхий зөвлөмжийг 2 газарт хүргүүлээд байна.

Мөн ус хангамжийн төвлөрсөн болон төвлөрсөн бус эх үүсвэр, ус түгээх цэг зэрэг 5 газрын 21 цэгийн усыг СХЗХ-ийн лабораторид хими, нян судлалын үзүүлэлтээр шинжилгээнд хамруулсан, шинжилгээний дүн гараагүй.

Аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу сүлжээ дэлгүүрийн үйл ажиллагаанд шалгалт хийж, 6 заалт бүхий зөвлөмж хүргүүлж, үйл ажиллагааны дүгнэлт гарган мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ орон нутагт ажилласантай холбоотой Эрүүл мэндийн сайд С.Чинзориг аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, эрүүл мэндийн салбарын ажилтан албан хаагчидтай уулзан санал солилцож ажилласан. Уулзалтаар тус аймгийн Нэгдсэн эмнэлэгт нэн шаардлагатай унтуулгын аппарат, хүчил шүлтийн тэнцвэр тодорхойлогч аппарат, зөөврийн рентген аппаратыг шийдвэрлэхээр болсон.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн гэмтэл, мэс заслын тасгийн эмч, мэргэжилтнүүд Гэмтэл согог судлалын үндэсний төвийн хавсарсан гэмтлийн тасагтай хамтран цээжний хөндийн битүү гэмтэл хавсарсан хүнд өвчтөнд олон хавирганы тогтворгүй хугарлыг бэхлэх мэс заслын яаралтай тусламжийг орон нутагтаа үзүүллээ.

“Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй хүн амыг эрт илрүүлэх, үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр Улсын нэгдүгээр төв эмнэлийн эмч нарын баг аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Эрүүл мэндийг дэмжих төв”-д 8 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд ажиллаж, дотоод шүүрэл, зүрх судас, хэвлийн эхо, бамбайн эхо, хөхний эхо, нүүр амны мэс засал, хоолны зөвлөгөө, ходоодны дуран, Бэлгийн замаар дамжих халдвар зэрэг чиглэлээр зөвлөгөө үзлэг, оношилгоо хийлээ.

Глобаль сангийн дэмжлэгтэй “Монгол улсад ДОХ, Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг эмчлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэх, дэмжлэг үзүүлэх” төслийн хүрээнд эрсдэлт бүлгийн хүн амын дунд халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг шинжилгээг 2023 оны 9 дүгээр сарын 18-23-ны хооронд зохион байгуулан ажилласан.

Австралын олон улсын хөгжлийн агентлаг, "SIGHT FOR ALL" олон улсын байгууллага, АШУҮИС, МУЗН-ын хамтарсан төслийн хүрээнд Нүдний үзлэг оношилгоо хийх 6150\$ үнэ бүхий зөөврийн 5 төрлийн багаж хэрэгслийг гардуулан өгсөн.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Ажил олгогчоос ирүүлсэн сул чөлөөтэй ажлын байрны захиалга болон ажил зуучлагдсан иргэдийн мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд ажил хайгчаар 41 иргэнийг бүртгэж оруулсан ажил зуучлалд 7 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан, түр ажлын байранд 11 иргэнийг зуучилсан.

Сүмбэр суманд 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр, Шивээговь суманд 09 дүгээр сарын 12-ны өдөр “Төрийн байгууллагуудын нэгдсэн нээлттэй хаалганы өдөрлөг” арга хэмжээгээр 110 иргэдэд хөдөлмөрийн зах зээлийн талаарх мэдлэг мэдээллийг олгосон.

Арга хэмжээнд хамрагдсан ажил хайгчаар бүртгүүлсэн 8 иргэний мэдээллийг ижоб мэдээллийн нэгдсэн санд ажил хайгчаар оруулаад байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээ:

-2020-2023 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн хэрэгжилтэд хяналт тавьж тайлант хугацаанд 19,650,000 төг төвлөрүүлсэн байна.

-2023 онд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан санхүүжилтын зарцуулалтын тайланг 25 иргэнээс бүрдүүлэн авсан.

Хөтөлбөрийн бүрэн хэрэгжээгүй арга хэмжээнүүдийг иргэдэд ил тод нээлттэй сурталчилж, ажилгүй, ажил олоход хүндрэлтэй иргэдийг хамруулж, дэмжлэг үзүүлж, хэрэгжилтийг хангасан байна.

-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн тушаалаар батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн санхүүгийн төслийн хэрэгжилтэд хяналт хийх ажлын удирдамжийн дагуу 89 иргэний төслийн хэрэгжилтэд хяналт хийж, зөвлөмж өгч ажилласан.

Старт–Апп залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган Google form ашиглан 32 иргэнийг бүргэсэн байна. Сонгон шалгаруулалтын ажлыг 9 сарын сүүлээр хийхээр төлөвлөсөн байна.

-Ажилгүй, ажил олоход хүндрэлтэй 17 иргэнийг түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагааны мод тарих арга хэмжээ нийтийг хамарсан арга хэмжээнд хамруулж 6120.0 мян.төг цалин олгож ажилласан.

-Хүүхэд хамгаалагч төсөлд 5,6 сард хамрагдан ажилласан 2 ахмад үргэлжлүүлэн хуваарийн дагуу ажиллаж эхэлсэн байна.

-Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд Хүнс хөдөө аж ахуйн газраас ирсэн төсөл ажлын хэсгийн хурлаар дэмжигдэн 3 ахмад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээ:

2023 оны 09 дүгээр сарын 20-ны байдлаар зорилтот бүлгийн иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг нийт 12331 иргэнд цаг тухайд нь олгож, түргэн шуурхай үйлчилсэн.

2023 оны 09 сарын 12-ны өдөр Шивээговь суманд зохион байгуулагдсан "Төрийн үйлчилгээний нээлттэй хаалганы өдөрлөг"-т оролцож, нийгмийн халамжийн үйлчилгээг 30 иргэнд хүргэж, 100ш гарын авлага тараан ажилласан.

Аймгийн хэмжээнд амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 4 удаа зохион байгуулж, 26 иргэний асуудлыг хэлэлцэж, зорилтот бүлгийн иргэдэд тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээг үзүүлсэн.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хяналт хийж, 47 өрхийн хувийн хэргийн баримтын бүрдэл дутуу байсныг иргэдэд утсаар мэдэгдэн 2023 оны 08 дугаар сарын 20-ноос 09 сарын 05-ны дотор баримтын бүрдлийг бүрэн болгож ажилласан. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн дэлгэрэнгүй судалгааг шинэчлэн ажилласан. Политехникийн коллеж руу хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй 18-45 насны иргэдийн судалгааг гарган хүргүүлсэн.

2023 оны 09 сарын хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд аймгийн хэмжээнд 42 өрхийн 219 гишүүнд олгохоор олголт үүсгээд байна.

Ehalmj.mn системээр дамжуулан иргэдийн үйлчилгээг бүртгэн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжид 701 иргэний, жирэмсэн эхийн тэтгэмжид 142 иргэний тэтгэмжийг илгээсэн. Хүүхдийн мөнгөн тэтгэмж 9 сард 7176 хүүхдийн олголтыг үүсгэж илгээсэн.

2023 оны 09 сарын 20-ны байдлаар ахмадын хөнгөлөлт тусламжийг 58 иргэн, ХБИ-ний хөнгөлөлт, тусламжийг 84 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. Үүнд:

- "Тунгалаг аялгуу" ХХК-тай хамтран сонсголын бууралттай 5 ахмад, 3 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд сонсголын дижитал аппаратны хөнгөлөлтийг үзүүлсэн.

- "Очирт тулга" ХХК-тай хамтран 11 ахмад настан, 6 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлт үзүүлсэн.

- Сүмбэр, Шивээговь, Баянтал сумын иргэдэд түлээ нүүрсний хөнгөлөлтийн зар хүргэн, 75 хөгжлийн бэрхшээлтэй иргэний түлээ нүүрсний хөнгөлөлтийн баримтыг хүлээн авч, материалыг ehalmj.mn программд шивэн олголтод өгсөн.

- Ахмад дайчин, гавьяат цолтон ахмадад орон сууцны дулааны хөлс, түлээ нүүрсний хөнгөлөлтөө авах талаар утсаар мэдэгдэж, 6 гавьяат цолтон ахмадын баримтыг хүлээн авч, материалыг ehalmj.mn программд шивэн олголтод өгөөд байна.

- Ахмадын амралт, сувилалд 26 ахмад, магадлан итгэмжлэгдсэн рашаан сувилалд 10 ахмад сувилуулсан.

- 2023 оны 08 сарын 25-ны өдөр аймгийн ахмадын хуралд НХХ-ийн дарга М.Үржинханд ахмад настны тухай хууль, ахмад настны хөнгөлөлтийн талаар, Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн мэргэжилтэн Э.Гантуяа ахмадын төсөл хөтөлбөрийн талаар тус тус мэдээлэл хийж, иргэдийн асуултад хариулт өгч ажилласан бөгөөд нийт 60 гаруй ахмад настан хамрагдсан.

Ахмадын баярыг угтан аж ахуйн нэгж албан байгууллагад харьяалалгүй 577 ахмадын нэрсийг сумдаас хүлээн авч, хяналт хийн ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлыг 2023 оны 09 сарын 14-ний өдөр нэг удаа зохион байгуулж, 2 хүүхдийн асуудлыг хэлэлцэж, байнгын асаргааны сунгалтыг хийсэн.

№	Үзүүлэлт	2023.01.01 2023.09.20
		Хүн тоо
1	Халамжийн тэтгэвэр	280
2	Нөхцөлт мөнгөн тэтгэмж	254
3	Амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж	242
4	Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	833
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	93
6	Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж	142
7	Алдарт цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	
8	Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1458
9	Цалинтай ээж	701
10	Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа	280
11	Насны хишиг	743
12	Өрх толойлсон эх, эцгийн тэтгэмж	42
13	Ихэр хүүхдийн тэтгэмж	3
14	Олон нийтийн оролцоонд түшиглэлэсэн халамжийн үйлчилгээ	84
15	Хүүхдийн мөнгөн тэтгэмж	7176
Нийгмийн халамжийн сангийн дүн		12331

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Монгол Улсад Мал эмнэлэг, үржлийн салбар Шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөгжиж Мал аж ахуйн салбарт томоохон хөгжил дэвшил авч ирсний түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлээ.

Ойг угтан дараах ажлуудыг зохион байгууллаа.

Улс, аймгийн аварга малчдын зөвлөгөөнийг зохион байгууллаа. Уг зөвлөгөөнөөр ашиглаж байгаа бэлчээрийнхээ даац багтаамжид тохируулан малын тоо толгойг барих, малыг эдийн засгийн эргэлтэд түргэн оруулах замаар өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломж, анхаарах асуудлыг хэлэлцлээ.

Мал аж ахуй бидний ирээдүй мэргэжил сурталчлах арга хэмжээг Хөдөө Аж Ахуйн Их Сургуультай хамтран хэрэгжүүлэв.

Хурдан морины их нас, дааганы уралдаан зохион байгууллаа.

100 жилийн ойн баярын хурал нэгдсэн арга хэмжээг 2023 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулж, хөдөө аж ахуйн салбарт үр бүтээлтэй ажилласан албан хаагч, ахмад үеийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын “Тэргүүний ажилтан”, “Говьсүмбэрийн төлөө” медаль, аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагналаа.

Мөн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.9, 3.3.10 заалтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн ХХААГ-ын 2023 оны төлөвлөгөөнд тусгасаны дагуу ашиг шимийн гарц, чанар, удам зүйн үнэлгээ, эрүүл мэндээр баталгаажсан шилмэл мал болон ашиг шимийг нь ашигладаг тэжээвэр амьтныг олон нийт, мал үржүүлэгчдэд сурталчлан таниулж, стандартын шаардлага хангасан хээлтэгч, хээлтүүлэгчийг аж ахуйн нэгж, иргэдэд борлуулах, малчид, мал үржүүлэгчдийн хөдөлмөр бүтээлийг үнэлж, урамшуулах, дотоод

үйлдвэрлэгчдийн борлуулалтыг дэмжих, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах, түншлэгч, түүхий эд бэлтгэгчээ олоход туслах зорилго бүхий уламжлалт арга хэмжээ “Говийн бүсийн түншлэл 2023” үзэсгэлэн худалдааг 09 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Уг үзэсгэлэн худалдааны үеэр “Шилмэл мал, шилдэг бүтээгдэхүүн шалгаруулахаас гадна үе үеийн үзэсгэлэн худалдааны шилмэл малын зургийн үзэсгэлэн гаргалаа.

Худалдаанд өөр аймаг, сумдаас үйлдвэрлэл эрхлэгчид оролцоогүй, зөвхөн өөрийн аймгийн нийт 64 үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид, малчид оролцож, 51.7 сая.төг-ийн бараа, бүтээгдэхүүн, 250.0 мян.төг-ийн хурган хуц борлуулжээ.

Ашиг шимийн үзүүлэлт	Эзэлсэн байр	Малын төрөл	Нас	Малын зүс, хоч	Хэмжээ	Сум	баг	Малчны нэр
Сүү	1	Ингэ	15	Хөх	1,900	Сүмбэр	4	Н.Энхбаатар
	1	Гүү	8	Хонгор	1,580	Сүмбэр	6	П.Доржсүрэн
	2	Гүү	9	Сартай хүрэн	1,300	Сүмбэр	6	П.Доржсүрэн
Амьдын жин	1	Азарга	8	Хүрэн	400 кг	Сүмбэр	4	Д.Батмөнх
	2	Азарга	9	Хонгор	363 кг	Баянтал	4	Б.Нямсүрэн
	1	Бух	2	Улаан халзан	462 кг	Баянтал	2	Г.Мөнхбаяр
	2	Бух	5	Хар сарман	570 кг	Сүмбэр	4	Ц.Алтанзул
	1	Хуц	3	Хундан	77 кг	Сүмбэр	6	Б.Тулга
	2	Хуц	5	Хар түрүүт	74 кг	Баянтал	2	Г.Мөнхбаяр
	3	Хуц	5	Шар түрүүт	68 кг	Сүмбэр	5	Б.Батбуян
	2	Ухна	6	Хүрэн	66,5	Сүмбэр	6	Б.Тулга
Эм хонь	1	Эм хонь	5	Хар түрүүт	63 кг	Баянтал	2	Г.Мөнхбаяр
	2	Эм хонь	5	Хар нүдэн	58 кг	Сүмбэр	5	Б.Батбуян
Гахай	1	Бодон		Сибирийн цагаан		Сүмбэр	3	Г.Алтанбаата

Мал аж ахуйн хаваржилтын талаар:

Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн “Өвөлжилт, хаваржилт болон ургац хураалтын бэлтгэл хангуулах тухай” 01 дүгээр албан даалгавар, нэгдсэн төлөвлөгөөний дагуу малчдын түвшинд бэлтгэх өвс, тэжээлийн тооцоог гаргасан.

Говьсүмбэр аймгийн малчдын түвшинд бэлтгэсэн байдал

Сумын нэр	Шаардагдах тэжээл /тн/				Тэжээлийн нэгжид шилжүүлснээр	Бэлтгэсэн тэжээл /тн/				Малчдын түвшинд тэжээл бэлтгэлийн хувь
	Бүдүүн			Эрдэс		Бүдүүн			Эрдэс	
	Өвс	Үйлдвэрийн тэжээл	Гар тэжээл	Давс, хужир, шүү		Өвс	Үйлдвэрийн тэжээл	Гар тэжээл	Давс, хужир, шүү	
Баянтал	1591	265	16	104	739	10	4.0	2.0	3.0	1.4
Сүмбэр	7455	1243	75	466	3462	46	4	8	2	0.9
Шивээговь	1199	200	12	73	556	5	5	0	2	1.3
Нийт	10245	1708	102	644	4758	61.0	13.0	10.0	7.0	1.1

Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт өмнөх сартай харьцуулахад 8 зээлдэгч зээлээ бүрэн төлж, зээлийн үлдэгдэл 56.433 сая төг-өөр буурсан байна. Өөрөөр хэлбэл 9 дүгээр сарын 19-ний байдлаар нийт 63 зээлдэгчийн 1.059 тэрбум.төг-ийн үлдэгдэлтэй байна. Зээлийн ангилалаар харуулбал: Хугацаа хэвийн-6, хугацаа хэтэрсэн-1, хэвийн бус-2, эргэлзээтэй-1, муу-53 байна.

Сумын нэр	Зээлийн тоо	Авсан Зээл	Бодсон хүү	Тооцсон алданга	Төлбөл зохих дүн	Төлсөн дүн	Эцсийн үлдэгдэл
Сүмбэр	38	1'011'970'000	74'060'141	353'191	1'086'383'332	313'864'942	772'518'390
Шивээговь	17	151'500'000	9'372'071	2'526'395	163'398'466	48'077'574	115'320'892
Баянтал	8	191'500'000	18'554'500	8'604'984	218'659'484	46'961'011	171'698'473
	63	1'354'970'000	101'986'712	11'484'570	1'468'441'282	408'903'527	1'059'537'755

2020, 2023 онд “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 12 аж ахуй нэгжийн төслийн зарцуулалт, эргэн төлөлтийн мэдээ тайланг авч нэгтгэв. 2023 оны 09 дүгээр сарын 19-ний байдлаар нийт 1.049 тэрбум төг-ийн үлдэгдэлтэй, 12 зээлдэгч байна. Үүнээс хугацаа хэвийн-7, хугацаа хэтэрсэн-1, эргэлзээтэй-2, муу-2 байна.

Зээлдэгчийн мэдээлэл /2020-2023/

№	Зээлдэгчийн мэдээлэл	Олгосон хэмжээ	Төлөөгүй үндсэн зээл	Төлөөгүй хүү	Үндсэн зээлийн бодит үлдэгдэл	Хугацаа хэтэрсэн хоног	Зээлийн ангилал
1	УЦЦЭЧ	71'000'000.00	27'884'837.64	1'975'162.36	68'862'868.42	589	Муу
2	Чойр нарлаг хүлэмж хоршоо	95'000'000.00	18'098'972.67	289'535.53	72'926'821.49	285	Эргэлзээтэй
3	Сүмбэр хишиг	100'000'000.00	20'119'867.41	1'148'132.59	77'834'979.15	285	Эргэлзээтэй
4	Чойрын богд шүтээн	58'000'000.00	-2'432.89	0.00	33'471'729.01	0	Хэвийн
5	Мэргэн дунгаа	64'000'000.00	27'062'845.30	1'444'514.95	64'000'000.00	620	Муу
6	Эрин зууны холбоос	60'000'000.00	-1'877'794.52	0.00	33'990'531.75	0	Хэвийн
7	Язгуур баялаг нэхий	100'000'000.00	0.00	-1'52	100'000'000.00	0	Хэвийн

	хоршоо						
8	Чойрын гурван богд хоршоо	100'000'000.00	0.00	752'533.48	100'000'000.00	73	Хугацаа хэтэрсэн
9	Оорцог элгэн хоршоо	100'000'000.00	0.00	-1.52	100'000'000.00	0	Хэвийн
10	Очирмөнх хайрхан	98'000'000.00	0.00	0.00	98'000'000.00	0	Хэвийн
11	Өрнөх чойр	240'000'000.00	0.00	0.00	240'000'000.00	0	Хэвийн
12	Педим инсайт повер	60'000'000.00	0.00	0.00	60'000'000.00	0	Хэвийн
		1'146'000'000.00	91'286'295.61	5'609'875.87	1'049'086'929.82		

Газар тариалангийн чиглэлээр:

2022, 2023 онд олгосон нийт 85 хүлэмжийн ашиглалтыг тооцоход Баянтал сум 78%, Шивээговь сум 60% ашиглалттай, Сүмбэр сум 60% ашиглалттай байна.

Аймгийн дүнгээр нийт 50.07 тн ургац хурааснаас төмс 23.37 тн, хүнсний ногоо 26.7 тн байна. Ургац хураалтын ажил үргэлжилж байна. 9 дүгээр сарын 14-15 ны өдрүүдэд “Говийн бүсийн түншлэл 2023” үзэсгэлэн худалдаанд нийт 10 ногоочин өөрсдийн тариалсан 13 төрлийн бүтээгдэхүүнээр оролцсон байна.

Хүнсний нөөцийн талаар:

Хүнсний нөөцийн бодит мэдээллийг сумдаас авч нэгтгэв. Үүнд: Аймгийн дүнгээр мах 22 тн буюу 10, гурил 34 тн буюу 30, сүү 3.8 тн буюу 1, төрөл бүрийн будаа 19 тн буюу 26, төмс 17 тн буюу 11, хүнсний ногоо 18 тн буюу 5, элсэн чихэр 6 тн буюу 15, давс 6 тн буюу 19, савласан ус 18 тн буюу 1, өндөг 1 тн буюу 10, ургамлын тос 4.2 тн буюу 18 хоногийн нөөцтэй байна.

№	Хүнсний нэр төрөл	Сүмбэр сум			Баянтал		Шивээговь	
		Хэм жих нэгж	Тоо хэмжээ	Хоногийн нөөц	Тоо хэмжээ	Хоногийн нөөц	Тоо хэмжээ	Хоногийн нөөц
1	Малын мах	тн	7.2	6	0	0	0	8
2	Гурил	тн	47.1	85	2	3.6	1	1.7
3	Гурилан бүтээгдэхүүн	тн	3.9	3	1.4	1.6	1.6	3
4	Төрөл бүрийн будаа	тн	15.2	22	1.6	30.7	0.5	1
5	Сүү	тн	3.1	1.8	0.3	1.4	1	0.9
6	Өндөг	тн	2.98	12	0.1	23	0.1	1
7	Ургамлын тос	тн	2.8	7	1	9.5	2	24
8	Төмс	тн	5.8	4.6	2	2.7	4	6
9	Хүнсний ногоо	тн	5.1	2.4	1.3	1.3	5	3
10	Элсэн чихэр	тн	1.9	11	1	16.6	2	19
11	Давс	тн	2.1	14	1	21.9	1	9

12	Савласан цэвэр ус	тн	13.04	12	8	0.7	8	2
----	-------------------	----	-------	----	---	-----	---	---

Төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний Аймгийн үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2023 оны 9 дүгээр сарын үнийн мэдээ

Үнийн мэдээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дотооддоо үйлдвэрлэж буй хонь, үхрийн мах 500 төгрөгөөр, төмс 200 төгрөгөөр, хүнсний ногоо 50-200 төгрөгөөр, гурил 800 төгрөгөөр өссөн бол импортын бүтээгдэхүүн болох элсэн чихэр 1060 төгрөгөөр, цагаан будаа 533 төгрөгөөр, ургамлын тос 2390 төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

2023 оны 09 дүгээр сарын 11-ний байдлаар гол нэрийн барааны үнэ өмнөх сараас 2.5 хувиар буурсан байна.

№	Бараа бүтээгдэхүүн		Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан
1	Үхрийн мах	Ястай	13000	12000	
		Цул	16000	16000	
2	Хонины мах	Ястай	9000	7500	
		Цул	13000	12000	
3	Адууны мах	Ястай	10000	8000	
		Цул	11000	8500	
4	Ямааны мах	Ястай	8000	7000	
		цул	11000	8500	
5	Тахианы мах	Гуя	12000	9600	
		мөч	12000	9400	
6	Лууван	монгол	2500	1800	
		хятад			
7	Төмс	монгол	1800	1400	
		хятад			
8	Байцаа	монгол	1800	700	
		хятад			
9	Чинжүү	монгол	7800	6000	
		хятад	5000	4500	
10	Манжин	монгол	2500	1000	
		хятад			
11	Сонгино бөөрөнхий	Монгол	2900	2200	
		Хятад	2350		
12	Помидор	монгол	10000	4000	
13	Өргөст хэмх	монгол	6500	5000	
14	Элсэн чихэр		4700	3800	
15	Будаа	Цагаан задгай кг	3850	3200	
		Шар слава кг	5100	5050	
		Гурвалжин будаа кг	7950	3900	
16	Сүү	Задгай	2800	2500	
		Сүү ХХК 0,5л	2300		
		Сүү ХХК 1л	4950	4550	
17	Тараг	Задгай	3000	3000	
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4350	4150	
18	Талх	Чойр талх	2300	2250	
19	Өндөг	ОХУ	450	370	
		Монгол	580	500	
20		Задгай дээд			

	Алтан тарианы гурил	Задгай 1-р зэрэг			
		Задгай 2-р зэрэг			
		Савласан д/дээд /			
		Савласан дээд	2560		
		Савласан 1-р зэрэг	2520		
		Савласан 2-р зэрэг			
21	Ургамлын тос	Олейна	8400		
		Алтан	5800		
22	Гоймон	Алейка			
		Лапша	4700		

Мал эмнэлгийн газар:

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/178 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/225 дугаар захирамжын дагуу Монголын Биокомбинат УТҮГ-т үйлдвэрлэсэн “цэцэг өвчнөөс сэргийлэх” 318600 тун вакцин хүлээн авч мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд хуваарилан дархлаажуулалтын ажлыг зохион байгууллаа. Дархлаажуулалтад 515 өрхийн 292231 толгой мал хамрагдаж гүйцэтгэл 92 хувьтай дууслаа.

Гоц халдварт бог малын мялзангаас сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/170 дугаар захирамжийн дагуу зохион байгуулж, 519 өрхийн 297057 толгой мал хамруулан 99 хувийн гүйцэтгэлтэй дуусгасан. Мөн шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх мал угааллагын ажилд 126 өрхийн 103806 толгой мал хамрагдаж гүйцэтгэл 45 хувьтай явагдаж байна.

Мал эмнэлгийн хяналтын чиглэлээр:

Монгол улсын Засгийн газрын 2023 оны "Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах" тухай 79 дугаартай тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн хамтарсан "Бүх шатны боловсролын сургалтын байгууллагуудын 2023-2024 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажилд урьдчилан сэргийлэх шалгалтын удирдамжийн дагуу Баянтал, Шивээговь сумдын Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн хоол үйлдвэрлэлд хэрэглэгдэж байгаа мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн нийлүүлж байгаа бэлтгэн нийлүүлэгчээс мал эмнэлгийн гэрчилгээгээр хүлээн авч, бүртгэдэг эсэх, мах, махан бүтээгдэхүүн, Сүү, сүүн бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн үеийн мал эмнэлэг ариун цэвэр эрүүл ахуйн нөхцөлд шаардлагыг хангаж буй хэсэгт урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж байна. Шалгалт үргэлжилж байна.

Мал эмнэлгийн газар, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори хооронд байгуулсан “Бруцеллёзын хээлтүүлэгчийн тандалт - 2023” гэрээ, удирдамжийн дагуу Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын хээлтүүлэгчийн 6 сууриас нийт 1076 ширхэг дээж цуглуулж бэлтгэсэн ба 50 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.

Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээний хүрээнд Мал эмнэлгийн газрын дэргэдэх лабораторийн чадавхийг дээшлүүлэхэд анхаарч холбогдох арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлж ирсэн ба 2021-2023 онд малаас гаралтай хүнсний бүтээгдэхүүний 1477 сорьцод шинжилгээний 1-8 стандарт арга зүйн дагуу шинжилгээ хийн 74400 төгрөгийг төвлөрүүлсэн байна.

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ,

Хүрээлэн буй орчны бохирдол, газрын асуудлын хүрээнд:

Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2023 оны 01/08 дугаартай “Техникийн ашигласан тос, хаягдал аккумуляторыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, ашигла, дахин боловсруулах үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Шивээ-Овоо ХК-нд хяналт шалгалт хийв. Хяналт шалгалтын Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга, байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч Д.Мөнх-Эрдэнээр ахлуулсан ажлын хэсэг хийж гүйцэтгэв. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага өгч ажиллав.

Үндэсний баяр наадмаар хог хаягдалгүй наадах уриалга гаргаж Баянтал, Шивээговь, Сүмбэр сумд бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулж, 33 байгууллага 2,4 тн хог хаягдал цэвэрлэсэн.

“Жорлонгоо өөрчилъе” аяны хүрээнд иргэдэд байгальд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, ХААН, ХАС, ТӨРИЙН банкуудаар ногоон зээлд хамрагдах боломжтой болсон талаарх мэдээллийн цахимаар болон 8 иргэнд гарын авлага, мэдээлэл өгсөн.

Байгаль орчны үнэлгээ, усны асуудлын хүрээнд:

Умард гүвээт халхын дундад талын сав газартай хамтран аймгийн хэмжээнд усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн заагийг ИТХ-аар шинэчлэн тогтоох, усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд тэмдэгжүүлэлт хийх ажлыг хийж гүйцэтгэж байна.

Аймгийн захиалгаар Ус ундрах ХХК-ны гүйцэтгэж байгаа ногоон багууламжийн усалгааны зориулалттай гүй өрмийн худаг гаргах ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

Шивээговь сумын Засаг даргын орлогч Ч.Сугармаагийн “Манай сумын 2 дугаар багийн нутагт Шивээ овоо уурхай явдаг замын зүүн гар талд эзгүй тал дээр хүмүүс хэдэн гэр барьж, контейнер буулгаж, машин техник ирсэн байгаа тухай иргэд, уурхайн ажилчдаас мэдээлэл ирсний дагуу сумын газрын даамал Т.Өлзийбуд, байгаль орчны мэргэжилтэн О.Отгонбаяр нар газар дээр нь очиж, нягталсан. Тодорхой ажил хариуцсан, мэдээлэл өгөх хүнгүй хятад иргэд, хашаа барихаар ирсэн ажилчид байна” гэсэн мэдээллийн дагуу Байгаль орчны салбарын хяналтын хүрээнд Шивээговь сумын нутаг дэвсгэр, Шивээ-Овоо уурхайн урьд байрлалтай Цотан жанжин транс ХХК-ны үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмшихээр авсан газарт хяналт шалгалт явуулсан. Тус газарт Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэлгүй, байгаль орчны менежментын төлөвлөгөө батлуулахгүйгээр үйл ажиллагаа явуулж, их хэмжээний нүүрс буулгахаар хүнд даацын олон машин маршрутын бус замаар тээвэр хийж цуваа үүсгэн, 510 тн нүүрс буулгасан зөрчлийг таслан зогсоож, Зөрчлийн хуулийн 7.1.1-д заасны дагуу Байгаль орчны хяналтын ахлах байцаагч 3,0 сая төгрөгийн торгууль ногдуулсан.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар:

Говьсүмбэр аймгийн Бэлчээрийн газрын өөрчлөлтийг Фото мониторингийн аргаар тодорхойлсон байна.

❖ Сүмбэр сум-Нийт мал бэлчээрлэх хоногийн тоо өвөл 180 хоног, зуны 60 хоног, хавар 60 хоног, боломжит даац нь 139588,94 байгаа хонин толгойд шилжүүлснээр 429554 болж бэлчээрийн даац 289965 толгой малаар буюу бэлчээрийн даац 307%-иар буюу 3 дахин их хэтэрсэн байна.

❖ Баянтал сум- Нийт бэлчээрлэх хонгийн тоо өвөл 122 хоног, зуны 122 хоног, хавар 212 хоног, боломжит даац нь 149386 толгой мал байгаа бөгөөд одоо байгаа малын хонин толгойд шилжүүлснээр 118372 толгой мал болж бэлчээрийн даац 79,2%-иар хэтрээгүй буюу бэлчээрийн даац сайн байна.

❖ Шивээговь сум- Нийт мал бэлчээрлэх хоногийн тоо өвөл 122, зуны 122 хоног, хавар 121 хоног, боломжит даац нь 64523,37 толгой мал байгаа бөгөөд одоо байгаа малын хонин толгойд шилжүүлснээр 81614 толгой мал болж бэлчээрийн даац 126% буюу 2 дахин их хэтрэлттэй байна.

Говьсүмбэр аймгийн хот тосгон, бусад суурин газрын мониторингийн 10 цэгт хөрсний бохирдлын судалгаа хийж ажиллалаа.

❖ Газар ашиглалтын явцад хөрсөн бүрхэвчинд антропогенийн нөлөөллөөр хайрга, чулуу элсээр хучсан тул байгаль дээрх хөрсний бүтэц алдагдсан. Хөрсний хүчтэй эвдрэл харьцангуй их, овоолго шороог энд тэндгүй асгах, ухсан нүх, тос бензины сав зэргээс хөрс нэлэнхүйдээ физик эвдрэлд орсон учир ачааллыг зохицуулах шаардлагатай.

❖ Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ, стандарттай харьцуулан үзэхэд элсэрхэг хөрсний хүлцэх агууламжтай харьцуулахад хар тугалга 12.5-33.4мг/кг-аар, зэс 32.5-497.7мг/кг-аар их байгаа нь хүнд металлаар бохирдсон гэж үзэж болно. Эдгээрээс бусад элементүүдийн агууламж нь хүлцэх агууламжаас даваагүй боловч цайрын агууламж ихсэх хандлагатай байна.

❖ Хөрсөн дэх E.Coli бактерийн, Анаэробын бичил биетэн Cl.prefrings бохирдолгүй цэвэр байна.

❖ Хөрсний эрүүл ахуйн стандартад заасан үзүүлэлтээс хэтрээгүй байгаа ч MNS 297:2019 стандарт (эрүүл ахуйн шинжилгээний стандарт)-ыг баримтлах шаардлагатай.

❖ Ургамлан нөмрөгийн талхлагдалт, болон бусад байгаль орчинд нөлөөлж болохуйц эрсдэлээс сэргийлж ажиллах, ургамалжуулахад хялбар, арчилгаа бага шаардах, тухайн талбайн үндсэн ургамалжилтын хэв шинжийг тооцон Улиас, Хайлаас, сөөгнөөс шар хуайс (Caragana arborescens), голт бор (Lilac) тарих нь зүйтэй.

❖ Газрын тухай хуулийн 50.1.1-д заасны дагуу (газрын төлөв байдал, чанарыг хадгалах, байгалийн аясаар болон хүний үйл ажиллагааны улмаас хөрсний үржил шим буурах, газрын ургамлын бүрхэвч талхлагдах, хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давсжих, бохирдох, хордохоос сэргийлэх арга хэмжээг өөрийн зардлаар хариуцах) газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах.

❖ Газрын тухай хуулийн 56.6-д заасны дагуу (хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана) орчныг бохирдуулахгүй байх, ногоон байгууламжийн эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлж газар ашиглалт төлөвлөлтийг сайтар тооцож, аль болох бага талбай элэгдэл, эвдрэлд өртөхөөргүй үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь зүйтэй.

❖ Хог хаягдлын тухай хуулийн 10.2.2 (хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн гэх мэт шаардлагыг хангасан хогийн савтай байх) гэсэн заалтыг мөрдлөг болгох.

❖ Хог ургамлын болон ихэнх ургамлын үрийн боловсрох хугацаа 7-8 дугаар сар гартал хүн, амьтаны хөл, салхиар дамжин үргэлжилдэг тул шарилжийг долоодугаар сар гарахаас өмнө үндсээр нь зулгааж хаях нь дахин ургахгүй байлгах хамгийн үр дүнтэй арга бөгөөд мөн шарилжийн ургалтыг дарангуйлдаг бодисуудыг ч ашиглаж болно.

❖ Ил задгай нүхэн жорлон хөрс, гүний усыг бохирдуулж, аливаа халдварт өвчин тархах нөхцөл болоод зогсохгүй хавдар үүсгэх эрсдэлтэй. Хөрс, усны бохирдол улмаар гэдэс болон бусад халдварт өвчнөөс сэргийлэх, хамгаалах зорилгоор нүхэн жорлонгийн MNS 5924:2005 стандартыг баримтлах, соруулдаг болон био, эко 00-ыг хэрэглэх шаардлагатай.

❖ Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу газрын төлөв байдал, улсын чанарын хянан баталгааг 5 жил тутамд хийлгэж байх, газрыг зүй зохистой ашиглаагүйгээс хөрсийг эрс доройтуулсан нөхцөлд “Газрын тухай” хуулийн зохих заалтын дагуу газар эзэмших эрхийг цуцлах хүртэл арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Геодезийн хатуу цэг тэмдэгтийн тооллого зохион байгуулахаар удирдамжийг байгууллагын даргаар батлуулан сумдын хэмжээнд 2023 оны 08 дугаар сарын 23-31-ний өдрүүдэд 104 цэг тэмдэгтийн тооллогыг хийн ажилласан.

Газар зүйн нэрийн хээрийн тодруулалтын ажлыг аймгийн хэмжээнд Эс Эм Стар Геойд ХХК нь хийж гүйцэтгэн тайлан мэдээг 2023 оны 08 дугаар сарын 26-ны өдөр сумдын газар зүйн нэрийн зөвлөлүүдэд хүлээлгэн өгсөн.

Барилга, хот байгуулалтын хэлтэс:

Шивээговь сумын 3-р цэцэрлэг 150 хүүхдийн өргөтгөлийн барилга: 1-р давхарын гадна дотор хана өргийн ажил хийгдэж байна. Ажил удаашралтай байна. Ажлын гүйцэтгэлийг сайжруулах график хугацааны дагуу ажлыг гүйцэтгэх чиглэл өгсөн. Ажлын гүйцэтгэл 60 хувьтай.

Аймгийн төвийн 2000м³ цэвэрлэх байгууламжийн ажил: Захиргаа аж ахуйн барилгын ажил 1-р давхарын төмөр бетон каркасын ажил хийгдсэн 2 дугаар давхарын багана дамнуруу арматур бэлтэц бэлтгэж байна. Реакторын барилгын цутгамал хана арматурчлал хэв хашмалын ажил 95 хувьтай хийгдэж байна.

Хорооллын аритгах татуургын шугам хоолойн ажил: 2ф110 даралттай шугам хоолойн ажил бүрэн хийгдсэн насос станцын барилгын ажил хийгдэж байна. Насос станц-2 барилгын ажил дээрхи гарч байсан алдаа дутагдлын сайжруулах зөвлөмж зөвлөгөө өгсөн зургийн байгууллагыг хяналтаа хэрэгжүүлэх талаар мэдэгдсэн.

Халуун усны барилга: барилгын гадна хана парapedны өрлөгийн ажил хийгдэж байна. Өрлөгийн ажил 60 хувьтай.

Аймгийн төвийн 2,8км авто замын ажил: авто замын ажлын гүйцэтгэл 70 хувьтай 1,2 хэсгийн асфальт бетон хучилт хүлээж авахад бэлтгэл 90 хувь

Сургалт зөвлөгөөн:

Говьсүмбэр аймгийн Барилгын салбарын ИТА, удирдлага, ГХБХБГ-н төлөөлөл гэсэн 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй 2023 оны 09 дүгээр сарын 13-нд Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрлах Мак-н цонх, блокны үйлдвэртэй танилцах ажлыг зохион байгуулж үйлдвэрлэлийн технологи, үйлдвэрийн байрны ХАБЭА-н чиглэлээр туршлага судалсан.

Орон нутгийн өмчийн талаарх:

Орон нутгийн өмчийн газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан “Орон нутгийн өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалат, түүний зарцуулалтын байдалд бүртгэлээр хяналт хийх” удирамжийн хүрээнд Сум дундын ойн ангийн үндсэн болон эргэлтийн хөрөнгөд бүртгэлээр хяналт хийсэн.

Шалгалтыг Сум дундын ойн ангийн 2016-2022 оны санхүүгийн тайлангаар хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөд бүртгэлээр хяналт хийж, 2023 оны хагас жилийн дүнгээр хяналтын тооллого явуулж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдалтай танилцах, тогтоол шийдвэрийн биелэлтийг ханган ажиллаж байгаа эсэхийг тогтоож, зөрчил дутагдлыг арилгуулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах зорилготой хийж гүйцэтгэсэн байна.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА:

Аймгийн хэмжээнд худалдан авах ажиллагааны явц:

Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн 11 дугаар “Аймгийн 2023 оны төсвийг батлах тухай” тогтоолыг баталсантай холбоотойгоор “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ

худалдан авах” тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4-т заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 11-ний өдөр баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Сангийн яаманд хүргүүлж батлуулсан, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /tender.gov.mn/ сайтад ил тод нийтэлсэн. Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023оны 08 дугаар сарын 04ний өдрийн “Аймгийн 2023оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол батлагдсантай холбоотойгоор 2023 оны Төсвийн ерөнхийлөн захирагчаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн батлуулж , Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /tender.gov.mn/ сайтад ил тод нийтэлсэн.

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяа 3 сум буюу Сүмбэр, Баянтал, Шивээговь /харьяа сургууль, цэцэрлэг/, төсөвт байгууллагууд, Илчлэг Шивээ ОНӨТҮГ, Талын Илч ОНӨТҮГ, Тохижилт Сүмбэр, УС-Ду ОНӨТҮГ, Аж ахуйн тооцот үйлдвэрийн газрын худалдан авах ажиллагааны Засгийн газрын тогтоосон босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа ажил үйлчилгээг жилийн төсөв батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор ТЕЗ-аар баталгаажуулж Сангийн яамаар батлуулах,

Сангийн сайдын баталсан төлөвлөх, тайлагнах журмын Маягт 5 дагуу Орон нутгийн өмчийн газар ирүүлэх хагас, бүтэн жилээр тайланг ирүүлэх чиглэлийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, арга зүйн зөвлөгөөгөөр хангасан.

Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ-ийн танхимын сургалтыг 2023 оны 04 дүгээр сарын 13-аас 04 дүгээр сарын 16-ний хооронд зохион байгуулсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчид 2023 онд нийт 8,279,947.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 26 бараа, ажил, үйлчилгээ худалдан авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан байна. Үүнээс нэг ч тендер шалгаруулалт зарлаагүй байна. Худалдан авах ажиллагааны явц 70 хувьтай байна.

Үйл ажиллагааны явцад төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй. Төлөвлөгөөний биелэлтийг санхүүжилтийн эх үүсвэрээр нь ангилбал:

Улсын төсвийн хөрөнгө оруултаар 4,194,800.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс:

- ✓ Үнэлгээ хийгдэж байгаа төсөл арга хэмжээ – 1 / 85,000.0 мянган төгрөг/
- ✓ Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ -1 / 4,109,800.0 мянган төгрөг/

Төлөвлөгөөний биелэлт 50 хувь.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар

- 1,023,869,4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс:

- ✓ Тендерийн шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарласан төсөл арга 1/ 52,000.0 мянган төгрөг/
- ✓ Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 5 / 923,869.4 мянган төгрөг/

Төлөвлөгөөний биелэлт 80 хувь.

Аймгийн “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр 2,451,959.1 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 төсөл арга хэмжээ төлөвлөснөөс:

- ✓ Тендерийн шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарласан төсөл арга хэмжээ – 1 / 546,549.9 мянган төгрөг/
- ✓ Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 10 / 1,752,409.2

мянган төгрөг/

Төлөвлөгөөний биелэлт 80 хувь.

Аймгийн “Авто замын сан”-ийн хөрөнгөөр 440,616.5 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажил төлөвлөснөөс:

- ✓ Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 1 / 440,616.5 мянган төгрөг

Төлөвлөгөөний биелэлт 100 хувь.

Аймгийн “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал”-аар 28,702.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажил төлөвлөснөөс:

- ✓ Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 1 / 28,702.0 мянган төгрөг

Төлөвлөгөөний биелэлт 100 хувь.

Аймгийн “Бусад хөрөнгө оруулалт”-аар 28,702.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажил төлөвлөснөөс:

- ✓ Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 1 / 100,000.0 мянган төгрөг

Төлөвлөгөөний биелэлт 60 хувь

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасныг үндэслэн худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгон зарласан байна. Үүнд:

- Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан - 13
- Харьцуулалтын аргаар - 9
- Зөвлөх үйлчилгээний тендер – 4

Худалдан авах ажиллагааны ил тод байдлын хүрээнд:

Зарлагдсан тендерийн урилгуудыг “Монголын мэдээ” сонин, www.tender.gov.mn, govisumber.gov.mn сайтуудад тухай бүр нийтлэхээр, тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр явуулахаар төлөвлөж байна. Тендер шалгаруулалты үр дүнг тухай бүрт нь цахим системд оруулан ажиллах болно.

Шилэн дансны вэб сайтад 2023 оны 08 дугаар сарын худалдан авах ажиллагааны явцыг 2023 оны 10 дугаар сарын 03-нд байршуулна.

Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газрын хэрэгжүүлсэн дуудлага худалдааг цахим болон танхим хэлбэрээр зохион байгуулахад зориулсан тусгай өрөөний туршлагаас солилцох шугамаар 2023 оны 09 дүгээр сарын 20-ноос 22-ны өдрүүдэд албан хаагчид томилолтоор ажилласан.

Тус хэлтсийн Хими хор, нян судлал хорио цээрийн лаборатори нь нийт 120 сорьцод 661 үзүүлэлтээр хими, нян судлалын хорио цээрийн шинжилгээг хийж гүйцэтгэн, хариуг баталгаажуулсан. Шаардлага хангаагүй 31 сорьц илэрч, холбогдох улсын байцаагч нарт хариуг хүргүүлсэн.

Дээрх 120 сорьцоос 82 сорьц нь Аж ахуй нэгж, иргэнээс ирүүлсэн дээж байсан бөгөөд 243 үзүүлэлтээр шинжилгээг хийж 2,167,500 төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Мөн Улсын байцаагчийн хяналт шалгалтаар ирүүлсэн 38 усны дээжид 418 үзүүлэлтээр 2,119,600 төгрөгийн төлбөргүй шинжилгээ хийж гүйцэтгэсэн.

Мөн Усны шинжилгээний ажлын хуудас шинээр боловсруулсан. Химийн лабораторийн бэлэн байдлыг хангаж, 7 төрлийн бодис урвалжийг найруулан, 215 шил савыг угааж ариутгасан. Лабораторийн дотор, гадна камерыг хэвийн ажиллагаанд оруулсан.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР